



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН  
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 10 сарын 02 өдөр

Дугаар А/1444

Улаанбаатар хот

Журам, гэрээний загвар  
шинэчлэн батлах тухай

Эрүүл мэндийн сайдын 2018 оны “Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг батлах тухай” А/21 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтын 2.2.6, 4.7.1, 4.7.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2-р байранд төгсөлтийн дараах сургалтанд суралцаж байгаа орон нутгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд болон бусад байрлагсдыг байрлуулахтай холбогдох харилцааг зохицуулах зорилгоор “Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 2-р байрны дотоод журам”-ыг нэгдүгээр, “Байранд түр байрлуулах гэрээний загвар”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Байранд байрлагчидтай гэрээ байгуулан батлагдсан дотоод журмыг мөрдүүлж ажиллахыг Захиргаа, санхүү, дотоод хяналтын албаны Аж ахуйн менежер /Ч.Тунгалаг/ -т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүү, дотоод хяналтын албаны дарга /Т.Содгэрэл/-д даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ерөнхий захирлын 2018 оны “Байрлагсдын журам, гэрээний загвар батлах тухай” А/85 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Б.НАРАНТУЯА

010506

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн  
Ерөнхий захирлын 2019 оны 10 дугаар  
сарын 02-ны өдрийн 114 дугаар тушаалын  
нэгдүгээр хавсралт



## ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН 2-Р БАЙРНЫ ДОТООД ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь төгсөлтийн дараах сургалтанд суралцаж байгаа орон нутгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд болон бусад байрлагсдыг ЭМХТөвийн 2-р байранд түр оршин суухад нь ая тухтай орчин бүрдүүлэх, байрлагч байрны хэвийн үйл ажиллагааг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Байранд түр оршин суухтай холбогдсон харилцааг “Байранд түр байрлуулах гэрээ”-гээр тусгайлан зохицуулна.

1.3. Байрны нийт орны 90–ээс доошгүй хувьд төгсөлтийн дараах сургалтанд суралцаж буй эмнэлгийн мэргэжилтнийг, 10 хүртэлх хувьд албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилгоор Эрүүл мэндийн яам болон Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ажиллагсдыг байрлуулж болно.

### Хоёр. Байранд орох эрх олгох

2.1. Хөдөө орон нутгаас төгсөлтийн дараах сургалтанд хамрагдахаар ирсэн эмнэлгийн мэргэжилтэн /байрлагч/ нь байранд орох хүсэлтээ Төвийн захиргаанд бичгээр гаргана.

2.2. Захиргаа байранд орох хүсэлтийг бүртгэн ил тод, нээлттэй байдлаар сонгон шалгаруулах замаар шийдвэрлэнэ.

2.3. Төвийн Захиргаа, санхүү, дотоод хяналтын албаны Аж ахуйн менежер нь эрх авсан байрлагчдад өрөө тасалгаа хуваарилж, үнэмлэх олгон “Байранд түр байрлуулах” гэрээ байгуулна.

2.4. Байрлагсад нь хуваарилагдсан өрөөг солихыг хориглох бөгөөд зөвхөн хуваарилсан өрөөнд байрлана.

2.5. Амьдрах зайлшгүй шаардлагатай ажиллагсдыг өргөдөл, хүндэтгэн үзэх шалтгааныг судалж төвийн Ерөнхий захирлын шийдвэрээр эрх олгоно.

### Гурав. Байранд оруулах, гаргах

3.1. Байранд амьдрах эрх авсан эмнэлгийн мэргэжилтэн нь гэрээ байгуулахдаа дараах материалыг бүрдүүлж Захиргаа, санхүү, дотоод хяналтын албаны Аж ахуйн менежерт хүлээлгэн өгнө. Үүнд:

- Байрны төлбөр төлсөн баримт
- Иргэний үнэмлэхний хуулбар
- 2% зураг

- Суралцаж байгаа байгууллагын тодорхойлолт.

3.2. Үнэмлэх нь байранд нэвтрэх үндсэн баримт учир биедээ тогтмол авч явж, байранд орох бүртээ жижүүрт шалгуулж байранд нэвтрэнэ.

3.3. Гэрээний дагуу Захиргаа, санхүү, дотоод хяналтын албаны Аж ахуйн менежер өрөөг байрлагчдад хүлээлгэн өгөхдөө өрөөний тавилга, эд хогшлыг бүртгэлийн картаар олгож, түлхүүр өгнө.

3.4. Байранд оршин суух гэрээний хугацаа дуусах, гэрээг хугацаанаас өмнө цуцлах тохиолдолд өрөөг эд хөрөнгийн хамт Захиргаа, санхүү, дотоод хяналтын албаны Аж ахуйн менежерт хүлээлгэн өгч, хүлээлцэх акт үйлдэнэ.

3.5. Өрөөг бүрэн бүтэн хүлээлгэн өгөх, хүлээн авах асуудлыг Захиргаа, санхүү, дотоод хяналтын албаны Аж, ахуйн менежер хариуцана.

#### Дөрөв. Төлбөр, тооцоо

4.1. Байрны төлбөрийг Эрүүл мэнд, спортын сайд болон Сангийн сайдын хамтарсан 2015 оны 97/56-д заасан хэмжээгээр Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Төрийн сангийн 100900020020 тоот дансанд сар бүрийн 28-ны өдрийн дотор тушаасан байна.

4.2. Ажиллагсдын нийгмийн баталгааг хангах зорилгоор байранд амьдрах эрх авсан Эрүүл мэндийн яам болон Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ажиллагсдыг 50% хөнгөлөлттэй үнээр байрлуулна.

#### Тав. Байрлагчдад хориглох зүйлс

- 5.1. Байранд гадны хүн хонуулах;
- 5.2. Байранд амьдрахаас өөр зориулалтаар үйл ажиллагаа эрхлэх;
- 5.3. Байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх, тамхи татах, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ байранд нэвтрэх;
- 5.4. Бусдын амгалан тайван байдлыг алдагдуулах, танхайрах, хэт чанга дуу чимээ гаргах;
- 5.5. Ашиглалтын шаардлага хангахгүй цахилгаан хэрэгсэл хэрэглэх;
- 5.6. Байрлах эрхийг бусдад шилжүүлэх;
- 5.7. Байранд ил задгай хог хаях;
- 5.8. Байранд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 24:00 цагаас хойш нэвтрэх.

#### Зургаа . Байрлагчийн үүрэг, хүлээлгэх хариуцлага

6.1. Байрлагч нь энэхүү журмын дөрөв, тавдугаар зүйлийг зөрчсөн тохиолдолд байрлуулагчийн шийдвэрээр мэдэгдэх хуудас өгөх бөгөөд мэдэгдэх хуудас 2 удаа авсан тохиолдолд гэрээг цуцлана.

6.2. Байрлагч нь байрнаас гарахдаа хүлээн авсан эд хөрөнгийг үрэгдүүлсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.

6.3. Байрлагч нь 14 хоногт нэг удаа өөрийн байрлаж байгаа өрөөний гадна коридорын, сард нэг удаа байрны гадна орчны их цэвэрлэгээ тус тус хийж

Захиргаа, санхүү, дотоод хяналтын албаны Аж ахуйн менежер болон Байрны зохион байгуулагчид мэдэгдэх үүрэгтэй. Дотор болон гадна цэвэрлэгээ хийгээгүй байрлагчдад мэдэгдэх хуудас өгнө.

6.4. Байрлагч нь эзгүй үедээ өрөөний түлхүүрийг байрны жижүүрт хүлээлгэн өгөх ба байранд хоноогүй буюу хөдөө орон нутагт явах тохиолдолд хариуцаж буй ажилтанд заавал мэдэгдэж бүртгүүлсэн байна.

6.5. Байрлуулагч нь байранд шалгалт хийх үед чанарын шаардлага хангахгүй болон аюултай зүйл илэрвэл байрлагчаас гаргахыг шаардах бөгөөд байрлагч нь шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

----- о О о -----



Эрүүл мэндийн хөгжлийн төвийн  
Ерөнхий захирлын 2019 оны 0 дугаар  
сарын 02 ны өдрийн 1/ч дугаар тушаалын  
хоёрдугаар хавсралт



БАТЛАВ:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН  
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

### Байранд түр байрлуулах гэрээ

20 ... оны ... сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

#### Нэг: Ерөнхий зүйл

1.1. Энэхүү гэрээг нэг талаас Эрүүл мэндийн хөгжлийн төв, түүнийг төлөөлж Аж ахуйн менежер албан тушаалтай Ч.ТУНГАЛАГ /цаашид “Байрлуулагч” гэх/, нөгөө талаас ... овогтой ... РД: ... /цаашид “Байрлагч” гэх/ нар доорхи нөхцлийг харилцан тохиролцож энэхүү гэрээг 20 ... оны ... сарын ... -ны өдрөөс 20 ... оны ... сарын ... -ны өдрийг хүртэл ... /сар, жил/-ын хугацаагаар байгуулав.

#### Хоёр: Байрлуулагчийн эрх, үүрэг

- 2.1. Байрлагч нарт байрны дотоод журмыг танилцуулж, байр ашиглалтын болон аюулгүй байдлын зааварчилгаа өгөх;
- 2.2. Байрлуулагч нь байрлагчаас байрны дотоод журмыг мөрдөж, төлбөр тооцоог тогтоосон хугацаанд барагдуулахыг шаардах;
- 2.3. Байрны төлбөрийг үндсэн болон төрөлжсөн мэргэжлийн сургалтад улсын төсвийн санхүүжилтээр суралцагчдын тэтгэлэгээс суутгаж авах;
- 2.4. Байрлагчаас байрны үйлчилгээний чанар, хүртээмж, эвдрэл гэмтлийн талаар гаргасан санал, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх;
- 2.5. Өрөөний ашиглалтад хяналт тавих;
- 2.6. Байрлагч зөрчил гаргасан тохиолдолд захиалагч, суралцуулагч байгууллагад мэдэгдэх;
- 2.7. Байрлагч байрны дотоод журам зөрчсөн, энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд мэдэгдэх хуудас өгөх, гэрээг байрлуулагч дангаар цуцлах;
- 2.8. Байрлагчийн буруугаас учирсан хохирлыг нөхөн төлүүлж байгууллагыг хохиролгүй болгох;
- 2.9. Байрлагчийг 24:00 цагаас хойш байранд нэвтрүүлэхгүй байх;
- 2.10. Сантехник, цахилгааны талаар гарсан осол, гэмтлийг тухай бүр шуурхай

мэдээлэн засуулах арга хэмжээ авах;

2.11. Байрны галын аюулгүй байдлыг хангах материаллаг баазыг бэхжүүлэх, түүнийг хэрэгжүүлэх дүрэм, журмыг танилцуулж баталгаа гаргуулах;

2.12. Зайлшгүй засвар үйлчилгээ хийх тохиолдолд ус, цахилгааны хязгаарлалт хийх.

### **Гурав: Байрлагчийн эрх, үүрэг**

3.1. Байрлагч нь байрны дотоод журамтай танилцан, журмын болон гэрээний заалт нэг бүрийг чанд сахин биелүүлэх;

3.2. Байрлагч нь байгууллагын ажилтан албан хаагч, жижүүр, үйлчлэгч болон бусад байрлагчтай зөв зохистой харьцаж, байрлуулагчийн тавьсан шаардлагыг биелүүлэх;

3.3. Байрлагч нь байранд болон нийтийн эзэмшлийн газарт тамхи татах, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх, хог хаях, чанга дуу чимээ гаргах, зорилгогүй сэлгүүцэх зэргээр бусдын амгалан тайван байдлыг алдагдуулах, зүй бус авир гаргахгүй байх;

3.4. Нийтийн хэв журмыг зөрчин танхайрах, бусдын эд зүйлийг хулгайлах, цонхоор хүн оруулах, гаргах, хонуулах зэрэг зөрчил гаргахгүй байх;

3.5. Заасан хугацаанд байрны дотор болон гадна их цэвэрлэгээнд оролцох;

3.6. Өрөөний эд хогшил, цахилгаан, сантехникийн эд зүйлийн бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүйгээр зориулалтын дагуу ашиглах бөгөөд өөрийн буруугаас эд зүйлийг эвдэж, гэмтээсэн, үрэгдүүлсэн тохиолдолд учирсан хохирлын үнийн дүнг зах зээлийн үнээр төлөх;

3.7. Байрны төлбөрийг үндсэн болон төрөлжсөн мэргэжлийн сургалтад улсын төсвийн санхүүжилтээр суралцагчид тэтгэлэгээс суутгаж төлөх;

3.8. Дотуур байрны төлбөрийг тогтоогдсон тарифын дагуу гэрээ байгуулахаас өмнө урьдчилан гурван сараар, гэрээ байгуулсны дараа байрны төлбөрийг сар бүрийн 28-ны өдрийн дотор Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Төрийн сангийн 100900020020 тоот дансанд тушааж төлсөн баримтыг Байрны зохион байгуулагчид өгөх;

3.9. Байрны ариун цэврийн шаардлага, гал түймрийн аюулгүй байдлыг хангаж, ус, цахилгаан, дулааныг хэмнэж хэрэглэх.

3.10. Байрлагч тухайн өрөөнийхөө битүүмжлэл, аюулгүй байдал, цэвэрлэгээ үйлчилгээг бүрэн хариуцах;

3.11. Болзошгүй аюулын үед байрлагчийн буруутай үйлдлээс болж гарсан хохирлыг бүрэн хариуцах;

3.12. Байрлагч нь байранд байрлахдаа өрөөний тавилга, эд зүйлсийг картаар хүлээн авч, байрлах хугацаандаа тавилга, эд зүйлсийн бүрэн бүтэн байдлыг хангаж, байрнаас гарахдаа хүлээлцэх акт үйлдэнэ;

3.13. Байрлагч нь гадагш гарахдаа өрөөний түлхүүрийг байрны жижүүр болон харуул хамгаалалтын ажилтанд хүлээлгэн өгөх ба байранд хоноогүй буюу хөдөө орон нутагт явсан тохиолдолд хариуцаж буй ажилтанд заавал мэдэгдэж бүртгүүлсэн байх;

### **Дөрөв: Гэрээг цуцлах үндэслэл**